# Тоодог

Монголын Шувуу Судлалын Сэтгүүл

Дугаар 1 2014.12 сар



Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв

# ТООДОГ

## Монголын шувуу судлалын сэтгүүл

*Туршилтын анхны дугаар*

Тоодог хэмээн нэрийдсэн энэхүү сэтгүүл нь Монгол орны болон ойролцоох бүс нутгийн шувуудын талаар хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өгүүлэл, тайлан, мэдээ, байгаль хамгааллын сэдэвтэй холбоотой товч тэмдэглэлүүд зэргийг хэвлэдэг Монголын шувуу судлалын сэтгүүл болно.

**Эрхлэн гаргагч:**

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв

**Редакцийн бүрэлдхүүн:**

**Ерөнхий редактор:**

Батбаярын Нямбаяр, PhD

Axel Braunlich

**Туслах редактор:**

Пүрэв-Очирын Ганхуяг

Andreas Buchheim

Галтбатын Батбаяр

**Редакторууд:**

Нацагдоржын Цэвээнмядаг, PhD, ШУА-ийн Биологийн Хүрээлэн

Нямсүрэнгийн Батсайхан, PhD, Монгол Улсын Их Сургууль

Баярбаатарын Бүүвэйбаатар, PhD, Wildlife Conservation Society

Ma Ming, Xinjiang Institute of Ecology and Geography, Chinese Academy of Sciences

Igor Fefelov, PhD, Irkutsk State University, Russia

Richard Reading, PhD, Denver Zoo, USA

Simba Chan, BirdLife Asia

Nail Moore, PhD,  Birds Korea, South Korea

Andrew Dixon, PhD, International Wildlife Consultants, UK

Oleg Goroshko, PhD, Daursky Nature Reserve, Russia

Dorjiev Tsidip Zaytuevich, PhD, Buryat State University, Russia

**English language editor:**

Vacant

**Сэтгүүлийн хаяг:**

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Ундрам Плаза 33 тоот,

Баянзүрх дүүрэг, Улаанбаатар 210349

И-мэйл: toodogjournal@wscc.org.mn

Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв нь Монгол улсын болон бүс нутгийн амьтан ургамлын төрөл зүйл, тэдний амьдрах орчин, нөөц баялгийг судалж танин мэдэх, зохистой ашиглах, хамгаалах хамгийн үр өгөөжтэй боловсронгүй арга замыг эрэлхийлэх, байгаль орчны сургалт, танин мэдэхүйн сурталчилгааны олон талт үйл ажиллагааг явуулдаг төрийн бус байгууллага юм.

www.wscc.org.mn

# ЗОХИОГЧДОД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ

Тоодог хэмээн нэрийдсэн энэхүү сэтгүүл нь Монгол орны болон ойролцоох бүс нутгийн шувуудын талаар хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын өгүүлэл, тайлан, мэдээ, байгаль хамгааллын сэдэвтэй холбоотой товч тэмдэглэлүүд зэргийг хэвлэдэг Монголын шувуу судлалын сэтгүүл юм.

Уг сэтгүүлд бүтээлээ өгөхийг хүссэн хүмүүс дараах дүрмийг баримтлан өөрийн бүтээлээ бэлдэж өгөхийг сэтгүүлийн редакцийн зүгээс хүсэж байна.

Сэтгүүлд өмнө нь хэвлэгдэж байгаагүй судалгааны эх бүтээлээ явуулах ёстой. Хүлээн авсан материалууд үндсэн өгүүлэл, товч мэдээ, байгаль хамгааллын мэдээ, сүүлд хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдийн тойм, болон ховор шувуудын тухай тэмдэглэл зэрэг хэлбэрээр хэвлэгдэнэ.

Бүх эх бичвэрүүдийг toodogjournal@wscc.org.mn гэсэн цахим хаягруу электрон байдлаар илгээнэ. Цахим шуудан илгээхдээ захидалын нэрний хэсэгт Toodog гэж бичээд ард нь эхний зохиогчийн нэр, илгээсэн он зэргийг доогуур зураасаар холбож бичнэ үү. Жишээ нь: Toodog_Bayarkhuu_2012. Зохиогчид явуулж буй бүтээлээ үндсэн өгүүлэл, товч мэдээ, байгаль хамгааллын мэдээ, сүүлд хэвлэгдсэн судалгааны бүтээлүүдийн тойм, эсвэл ховор зүйлийн тэмдэглэлийн аль нь болохыг бидэнд мэдэгдэх ёстой.

Редакцийн зүгээс ирсэн эх бичвэрүүдийг үзэж шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлох, өгүүлэлийн чанрыг сайжруулахын тулд нягтлан уншилт (peer review) хийх бөгөөд үүн дээр үндэслэн засвар хийхийг зохиогчдод зөвлөнө. Зохиогчид өөрсдийн судалгааны чиглэлээр ажилладаг судлаачдыг нэр заан өөрийнхөө бүтээлд нягтлан уншилт хийлгэх хүсэлтээ тавьж болно. Зохиогчид дахин зассан хувилбараа 60 хоногийн дотор редакторт буцаах ёстой. Зохиогчдод хэвлэгдэхэд бэлэн болсон хувилбарыг хэвлэлтээс өмнө явуулан эцсийн байдлаар хянуулах болно. Энэхүү эцсийн хувилбарыг зохиогч анхааралтай уншиж хэвлэлийн алдаа байгаа эсэхийг шалган редакторт аль болох хурдан буцаах ёстой.

Зохогчид бүтээлээ жилийн аль ч улиралд сэтгүүлийн редакцруу илгээж болох ба зохиогч хэвлүүлэхээр илгээсэн эх бичвэрийн талаар ерөнхий редактораас и-мэйлээр хүссэн үедээ лавлаж болно. Редактрууд тухайн эх бичвэр Тоодог сэтгүүлд хэвлэгдэх эсэх дээр эцсийн шийдвэр гаргах эрхтэй. Хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн эх бичвэрүүд 2 жилийн дараа цахим хэлбэрээр бүрэн эхээрээ олон нийтэд нээлттэй болж, сэтгүүлийн веб хуудаснаа нээлттэй хэлбэрээр тавигдах болно. Сэтгүүлийн зүгээс хэвлэгдсэн өгүүллийн pdf-файлыг сэтгүүл хэвлэгдсэний дараа зохиогчдод и-мэйлээр явуулна.

Тоодог сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхэд зохиогчоос ямар нэгэн хураамж авахгүй.

**Ерөнхий заавар**

Зохиогчид эх бичвэрээ бэлдэхээс өмнө энэхүү зааврын анхааралтай унших хэрэгтэй.

Илгээж буй эх бичвэрүүд нь монгол эсвэл англи хэл дээр байна.

Сэтгүүлд илгээж буй судалгааны ажлын эх бичвэрүүд Бүтээлийн нэр, Хураангуй, Түлхүүр үг, Оршил, Аргазүй, Үр дүн, Хэлэлцүүлэг, Талархал, Ашигласан бүтээл гэсэн дараалалтай байна.

Үндсэн гарчигуудыг том үсгээр бичнэ. (жишээ нь: ОРШИЛ, АРГАЗҮЙ, ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ТАЛАРХАЛ, АШИГЛАСАН БҮТЭЭЛ).

Аливаа зүйлийн шинжлэх ухааны нэрийг өгүүлэлэлийн үнсэн хэсэгүүд болон хураангуйд эхний удаа дурдахдаа  хаалтанд хийж бичнэ. Шувуудын шинжлэх ухааны нэрийг бичихдээ British Ornithological Union эсвэл Oriental Bird Clubaac гаргадаг шувуудын зүйлийн жагсаалтын хамгийн сүүлийн шинэчилсэн хувилбар эсвэл Монгол орны хэмжээнд тогтмол мөрдөгдөж байгаа жагсаалтыг баримтлана. Бүтээлийн нэрэнд онцын шаардлаггүй бол тухайн зүйл тодорхойлсон хүний нэр, он болон дэд зүйлийн тухайн дурдах хэрэггүй. Англиар бичигдэж буй өгүүлэлд шувуудын зүйлийн түгээмэл нэрний эхний үсгийг томоор бичих (Шилийн сар, гэх мэт) ба шувуудын бүлгүүдэд (бор шувууд, гэх мэт) энэ хамаарахгүй, мөн Монглоор бичиж байгаа тонхиолдолд томоор бичих шаардлаггүй.

Үсгийн хэмжээ 12 эсвэл 11 байх ба Times New Roman фонтыг ашиглана. Зохиогчдын хаяг, шинжлэх ухааны нэр, сэтгүүлийн нэрийг *Italic* хэлбэрээр бичнэ.

Хуудсыг дугаарлахдаа баруун доод булан зөв дарааллаар дугаарлана. Эх бичвэрийн бүх текстийг мөр хоорондын зайг давхар мөрөөр (double space) бичих ба зүүн талруу шахаж, захыг тэгшилнэ (justify) болгоно. Хуудасны 4 талд 25мм (1”) зай үлдээ. Дэд гарчгийн залгаа параграфаас бусад шинэ хэсэг бүрт (параграф) догол мөр авна (12.7 мм).

Эх бичвэрийн бүх хэсгүүдэд метрийн нэгж ашиглана. Мөн халууныг целсийн температур ашиглан 13°C г.м. тэмдэглэнэ. Мин, сек, км, см, мм зэрэг товчлолуудыг тайлбаргүйгээр ашиглана. Огноог бичихдээ жил, сар, өдөр гэсэн дараалаар бичнэ (жишээ нь: 2014 оны 12 дугаар сарын 22). Цагыг 24 цагийн хэлбэрийг ашиглана (жишээ нь: 07:30, 17:10-22:30 гэх мэт).

Зураг, хуснэгт бүрийг эх бичвэрийн текстэнд тоон дараалын дагуу хаалтанд дурьдсан байна. Нэг зүйлийн мэдээллийг хоёр хэлбэрээр давтах хэрэггүй (жишээ нь: текст болон хүснэгтэнд, эсвэл хуснэгт болон зурагт). Текстэнд иш татагдаж орсон бүтээлүүд иш татсан бүтээлийн жагсаалтанд орсон байх ёстой. Эсрэгээр иш татсан бүтээлийн жагсаалтанд орсон бүтээлүүд текстэнд иш татагдаж орон байна.

Текстэнд иш татаж буй бүтээлийг бичих дээ:

- Нэг зохиогчтой бол – Баатар (1999) эсвэл (Heater 1993). Зохиогч болон хэвлэгдсэн оны хооронд таслал авахгүй
- Хоёр зохиогчтой бол – Miller болон Dondog (1991) эсвэл (Сүрэн ба Дорж, 1990)
- Гурав болон түүнээс олон зохиогчтой бол – Сүрэн нар (1990) эсвэл (Сүрэн нар, 1990)
- Хэвлэлд зөвшөөрөгдсөн боловч хараахан хэвлэгдэж амжаагүй бол – Itochi (хэвлэлтэнд орсон) эсвэл (Itochi хэвлэлтэнд орсон)
- Хэвлэгдээгүй материалууд – B. Smith (хэвлэгдээгүй мэдээ), (B.Smith аман мэдээ) эсвэл B.Smith (аман мэдээ)
- Хэвлэгдээгүй болон аман мэдээнд тулгуурлсан материалуудыг ашигласан бүтээлийн жагсаалтад оруулахгүй
- Хэд хэдэн бүтээлээс ишлэл авахдаа хаалтанд оны дараалаа оруулж хооронд нь таслал тавьж тусгаарлана. (Heater 1993, Баатар 1999а, Баатар 1999б) эсвэл (Баатар 1999, Баатар ба Дорж 2000, Болд нар 2001).

Тоодог сэтгүүлийн ишлэлийн загвар нь Америкийн экологийн нийгэмлэгэс гаргадаг Ecology сэтгүүлийн загвартай төстэй. Endnote болон Reference manager ашигладаг зохиогчид Ecology сэтгүүлийн загварыг татаж аван ашиглах боломжтой.

**ГАРЧИГ**

Гарчгийг бүтнээр нь том үсгээр бичнэ. Гарчгийн дор зохиогчийн нэрийг голлуулж бичнэ. Зохиогчийн нэрийн дор зохиогчийн хаягийг бүтнээр ташуугаар (Italic) бичнэ. Хэрэв зохиогчийн хаяг тухайн судалгааны ажлыг хийж байх үеийнхээс өөрчлөгдсөн бол  зохиогчийн нэрийн ард дээд талд нь жижиг тоо тавьж одоогийн ажлыг илэрхийлэх бөгөөд хуудасны дор нэмэлт тайлбар бичнэ. Тухайн бүтээлийг хариуцах нэг зохиогчын (corresponding author) холбоо барих е-майл хаягыг бичнэ.

**ХУРААНГУЙ**

Үндсэн өгүүлэлд 200-аас илүүгүй үгтэй, нэг хэсэгээс тогтсон хураангуй байх ба үүндээ ишлэл авахгүй байх хэрэгтэй. Хураангуй нь товч байх шаардлагатай бөгөөд өгүүлэлийн зорилго багтсан үр дүнгээ аль болох онцолж бичих хэрэгтэй. Хураангуй нь монгол болон англи 2 хэл дээр байна.

Хураангуйн дараа 3-7 түлхүүр үгийг цагаан толгойн дараалаар бичнэ. Түлхүүр үгэнд шинжлэх ухааны нэр байвал ташуугаар (Italic), бусад тохилдолд хэвийн байдлаар бичнэ.

Эрдэм шинжилгээний өгүүллийн шинжтэй богино бүтээлүүд зөвхөн ганц хэл дээр бичигдсэн хураангуйтай байж болно. Зохиогч орчуулгыг хийж өгөх шаардлагатай ба орчуулж өгөөгүй тохиолдолд редактор хураангуйг орчуулах болно.

**ТЕКСТ**

Доорх журмыг мөрдлөг болгоно. Үндсэн гарчиг нь зүүн талд байрласан байна. Өгүүлэл нь ОРШИЛ, АРГАЗҮЙ, ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, ТАЛАРХАЛ, АШИГЛАСАН БҮТЭЭЛ гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Оршил нь текстээр эхлэх ба гарчиггүй байна. Дэд гарчгийг тодоор (Bold), гутгаар гарчгийг ташуугаар (Italic) бичнэ.

Товч мэдээ, тэмдэглэл, тойм мэдээ нь текст дотроо шаардлагатай бол гарчигтай бас фото зураг, графиктай байж болно.

**АШИГЛАСАН БҮТЭЭЛ**

Иш татаж байгаа бүтээлүүдээ эх материалтай нь заавал тулгаж шалгах хэрэгтэй.

Иш татсан бүтээлийг бичихдээ нэгдүгээр зохиогчийн нэрээр цагаан толгойн дараалаар бичнэ.

Нэг зохиогчийн олон бүтээлийг иш татсан бол нэг зохиогчтой бүтээлийг нь хэвлэгдсэн оны дараалыг үл харгалзан бусадтай хамтарч хийсэн бүтээлийнх нь өмнө нь бичнэ.

Нэг зохиогчийн олон бүтээлийг иш татахдаа хэвлэгдсэн оных нь дараалаар бичнэ.

Бүтээлийн болон сэтгүүлийн нэрийг товчилж болохгүй.

Хэвлэгдээгүй тайлан болон аман мэдээг иш татах хэрэггүй.

**ХҮСНЭГТ**

Хүснэгтийг аль болох энгийн хий. Богино өргөн байснаас урт нарийн хүснэгт хий.

Хүснэгт доторх текстийн мөр хоорондын зайг single space болгоно.

Хүснэгтийн нэр нь бүтэн өгүүлбэрээр аль болох ойлгомжтой дэлгэрэнгүй байх ёстой

Бүтээлийн бүх хэсэгт үсгийн хэв болон хэмжээ нэгэн ижил байх хэрэгтэй

Хүснэгтэнд босоо зураас битгий хэрглэ, зөвхөн үндсэн мөрийн доор болон хүснэгтийн доод талд хэвтээ зураас ашиглана уу.  MS Excel болон Word программын auto table функцыг ашиглах хэрэггүй. Хүснэгтээ өөрөө хийгээд хэвтээ  зураасыг гараар татах хэрэгтэй.

Хүснэгтэд тод үсэг ашиглах хэрэггүй

Их хэмжээний хүснэгтэн мэдээллийг хүснэгт хэлбэрээр болон хавсралт хэлбэрээр оруулах хэрэггүй. Жишээ нь шувуудын зүйлийн жагсаалтыг хавсралт маягаар хүлээн авах бөгөөд өгүүллийн дотор хэвлэхгүй, харин сэтгүүлийн веб хуудаснаас татаж авах линкийг оруулж өгөх болно.

**ЗУРАГ**

Зохиогч өнгөтөөр хэвлэх зардлыг төлөхгүй тохиолдолд зургууд нь хар цагаанаар байх хэрэгтэй

Зургууд нь үндсэн бичвэрт нэмэлт тайлбар хийх шаардлагагүй хялбар ойлгогдохоор, энгийн байх хэрэгтэй. Бүх зургийн үсэг, тоо нэг хэлбэрээр бичигдэнэ.

Зургийг дугаарлахдаа ромбо тоо ашиглаж болохгүй. Мөн дараалын хувьд үндсэн бичвэрт дурьдагдсан дараалыг мөрдөнө (жишээ нь Зураг 1, Зураг 2 гэх мэт).

График, схем, фото зураг, гар зураг бүгдийг “Зураг” хэмээн нэрлэн дугаарлана.

Зургууд нь хангалттай тайлбартай  байх шаардлагатай, ингэснээр үндсэн бичвэрт хэт их тайлбар бичихгүй байх боломжтой. Зургуудыг сэтгүүлийн нүүрний нэг баганад багтахаар хэмжээтэй болгон багасгаж болно.

Фото зураг нь 300 dpi-аас багагүй өндөр нягтралтай чанартай байх шаардлагатай. Хэрэв хэд хэдэн фото зургийг нэг бүлэг болгох бол өөр хооронд нь зайгүй нийлүүлэх хэрэгтэй.  Бүх фото зургийн эх файлыг тусад нь хавсаргаж өгөх шаардлагатай

Тухайн өгүүлэл хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн тохиолдолд бүх зураг, графикийн өндөр нягтшилтай эх хувилбарыг тусад нь файлаар өгөх шаардлагатай.